

Өгүүлэл

Эрүүл мэндийн салбар “эмгэгтэй” байна

Монгол хүн эрүүл байж Монгол Улс оршин тогтоно. Монгол хүний эрүүл мэнд үндсэн хуулиар хамгаалагдсан байдаг.

Тиймээс улс орны хамгийн чухал салбаруудын нэг бол яахын аргагүй эрүүл мэндийн салбар.

Тэгвэл манай улсын энэ салбар асуудал тарьсаар, асуудлаа дайрсаар, дайрч гарсаар өдийг хүрчээ. Үүний тухай баримтыг бичье.

Тухай үед эмчид итгэж, тэнгэрт залбирч эмнэлгийн үүд сахиж суусан эгэл жирийн малчин залуугийн гэр бүлд яг юу тохиолдов?

Баримт 1:

2019 оны нэгдүгээр сарын 24-ний өдөр Сүхбаатар аймгийн Наран сумын малчин айлын зургаан настай хүү хэвлий болон аюулхай хэсгээр хүчтэй базалж өвдөн сумын эмнэлэгт ирэхэд, тухайн өдөр ээлжинд ажиллаж байсан залуу сувилагч эмэгтэй "Гэдэс өвдөж халуурдаг ханиад их гарч байгаа. Танай хүүхдийнх бас л тийм ханиад байна. Биеийн байдал хэвийн, санаа зоволтгүй, түүхий ус ууж болохгүй шүү" гэж хэлээд өвчин намдаах эм, ханиадны эмтэй хамт бичиж өгөөд явуулжээ.

Сувилагчийн хэлсэн оношинд итгэж, бичиж өгсөн эмийг аваад уусан ч өвдөлт нь намдалгүй дотор нь муухайрч, бөөлжиж шөнийг арай ядан давжээ.

Маргааш өглөө дахин эмнэлэгт очиж сумын их эмчид үзүүлтэл "мухар олгойн үрэвсэл" гэсэн оношийг тавьж, өвчин намдаах дусал хийн яаралтай аймгийн төв эмнэлэг рүү сумын түргэний машинтай хүргэв.

Сүхбаатар аймгийн нэгдсэн эмнэлгийн эмч үзлэг хийж хэвлийн рентген зургийг авч "мухар олгой үрэвсэж хэвлий дотор хагарч, хэвлийн ханыг үрэвсүүлсэн, их удаан шархтай явсан байна" яаралтай мэс засал хийх шаардлагатай, цаг алдвал амь насанд халтай хэмээн хэлжээ.

Маш яаралтайгаар хагалгаанд орж, хэвлийн хана үрэвсэж бусад дотор эрхтэн шархалж дотуур цус алдсан байсан учир хагалгаа дөрвөн цаг үргэлжилжээ.

Сумын сувилагчийн худал оношинд итгэж тоохгүй өнгөрүүлж, цаг алдсанаас болж өнөөдөр бид хүүгээ алдах шахлаа гэж хэлэх эцэг, эх юу бодож суусан бол?

Сумын эмнэлгийн сувилагч өвчтөний оношийг гаргаж, дур мэдэн эм бичиж өгөх нь зөв үү?

Угтаа бол мэргэжлийн их эмч үзлэг хийж эмчилгээ бичиж өгөх ёстой атал тус сумын их эмчийн үүргийг энгийн сувилагч гүйцэтгэж байна. Мэргэжлийн алдаа гаргасан сувилагчийг ажлаас нь чөлөөлөөд өнгөрсөн байдаг.

Энэ тухай хүүгийн аав Б.Сугар:

“Хэлдэг газарт нь хэлж гомдол гаргасан ч гэсэн лам бөө хэл ам, хэрүүл тэмцэл хэрэггүй, гэснээр бид хүлцэж өнгөрсөн. Хэрүүл хийж явсан ч ядруухан малчин намайг тоох хүн байхгүй биз. Эмч нар нэгнийгээ хаацайлан өмөөрч, хир халдаадаггүй юм билээ хэмээн ярьсан юм.

Мэргэжил нэгт тэд нэгнээ өмөөрч, эмчийн алдар хүндээр халхавч хийсээр.

Энэ мэтчилэн хөдөөгийн алслагдсан буйдхан сумын төвд соёлын өвөө тээн мал сүргээ адгуулан буй малчдыг, эрүүл мэндийн энхийн манаанд гарч буй зарим цагаан халаадтай эмч нар “цаазалсаар” байх уу?

Стандартад нийцсэн эрүүл мэндийн төв, чадварлаг боловсон хүчнээр одоог хүртэл бүрэн хангагдаагүй байгаа нь хэний буруу вэ? Хамгийн чухал салбартаа улсын төсвөөс мөнгөн хөрөнгө тавихгүй эхдээ гологдсон ишиг шиг эрүүл мэндийн салбарыг гэж орхисоор байх уу?

2020 онд Сүхбаатар аймгийн эрүүл мэндийн газарт гурван тэрбум төгрөгийн санхүүжилтийг улсын төсвөөс төвлөрүүлсэн.

Энэ мөнгө юунд зарцуулагдав. Ядаж сумдынхаа эмнэлгийг чадварлаг боловсон хүчнээр хангах наад захын ажил хийгдээгүй байна.

Манай эмч нарын онош өөр хоорондоо зөрж гардаг. Үүнийгээ тоног төхөөрөмж рүү чихдэг асуудал одоо ч хэвээрээ байна.

Баримт 2:

2021 оны зургаадугаар сар. 50 настай эрэгтэй хөл гар нь мэдээ алдаж, бадайрч өвдөн хурдан алхаж ч чадахгүй болж, нуруу, хүзүү, цээжээр хатгуулан өвдөж Сүхбаатар аймгийн нэгдсэн эмнэлэгт хандан үзүүлж шаардлагатай зураг шинжилгээг өгсний эцэст “бага тархины харвалт” гэх оношийг тавьж 13А маягт өгч Улаанбаатар хот руу явахыг зөвлөжээ.

Улсын гуравдугаар төв эмнэлэгт ирж үзүүлтэл хүзүүний үе бэртэж бороолж эдгэн, хүзүүний үеийн “диск” мултарч гол судсыг дарсан учир гар хөл мэдээ алдсан байна хэмээн оношилж хагалгааг хийжээ.

Дахин нэг баримт 2018 он. Арван хоёрхон настай охин толгой эргээд өвдөж байна хэмээн тус аймгийн эмнэлэгт очиж тархины томограф зураг авхуултал түүний оношийг бас л буруу гаргаж “тархины цус харвалт” гэж оношилж Улаанбаатар хот яв гэжээ. Ар гэрийнхэн нь тухайн өдрөө шууд хотод ирж яаралтай үзүүлтэл тархины баруун хэсэгт бага зэрэг цус хуралт үүссэн байна. Энэ нь хүүхэд бага насандаа унаж толгойгоо доргиож хөнгөн бэртээх үед үүсдэг учир санаа зовж айх шаардлага байхгүйг сануулжээ.

Тус аймагт зарим нарийн мэргэжлийн тоног төхөөрөмж байдаг ч түүнийг ашиглаж, өвчний онош гаргаж, гарсан хариуг уншиж, оношийг тогтоож чадах хүн цөөн.

Сүхбаатар аймгийн хувьд 2023 онд эрүүл мэндийн даатгалын сангаас хөрөнгө оруулалт татаж тодорхой бүсийн таван байршилд дотор эрхтний оношлогч төхөөрөмж байршуулсан. Зарим төхөөрөмжийг ажиллуулах битгий хэл асааж ч чадах хүн байхгүй байгаа нь харамсалтай.

2023 оны статистик мэдээллээр Сүхбаатар аймгийн төв болон 13 сумын хэмжээнд 153 их эмчтэй гэсэн тоо байна.

Тодруулбал:

- Баруун урт 107, Асгат 4, Баяндэлгэр 8, Дарьганга 5, Мөнххаан 6, Наран 1, Онгон 4, Сүхбаатар 2, Түвшинширээ 3, Түмэнцогт 3, Уулбаян 3, Халзан 2, Эрдэнэцагаан 5. Тухайн сумдын хүн амын тооноос хамаараад их эмчийн тоо харилцан адилгүй байна. Жишээ нь:

Наран сумын хувьд 1 их эмчийн орон тоотой. Наран сум нь гурван багтай 1674 хүн амтай гэсэн 2023 оны мэдээлэл байна.

Энэ мэтчилэн хүн ам цөөн суманд ганцхан их эмчтэй, эмч нь амрах эрхгүй ажиллаж байна.

Сүхбаатар аймгийн хувьд аймгийн төвийн, сумын, өрхийн гэсэн нийтдээ 22 эмнэлэгтэй. Үүнд ахиад л чадварлаг боловсон хүчний асуудал яригдана. Чанартай

их сургууль төгссөн боловсон хүчнийг хувийн эмнэлгүүд өндөр цалин амлаж ажилд авдаг. Иймд Сүхбаатар аймгийн эрүүл мэндийн газар боловсон хүчин бэлтгэх тал дээр хэр ажиллаж байгаа гэдэг нь харагдана.

Мэдлэггүй, хаана ямар сургууль төгссөн нь, мэргэжлийн мэргэшсэн эмч эсэх нь тодорхой бус эмч нэртэй их зантай хэсэг бүлэг хүмүүсээс болж иргэд амь нас, эрүүл мэнд, цаг хугацаа, эдийн засгаараа хохирсоор л байх уу? Үүнд хэн хяналт шалгалт тавих ёстой вэ?

Эмчийн нэр сүрийг унаган гишгэлж, мэргэжлийн ноцтой алдаа гаргасаар байх уу? Олгой хагаравч тогоон дотроо гэсээр, манай эрүүл мэндийн салбар эмгэгтэй болжээ. Өөрсдийгөө дотроосоо эрүүлжүүлэх, чадварлаг хүний нөөц, ажиллах хүчээ бэлдэх, үүнийг нь төр бодлогоор дэмжих шаардлага үүсээд байна. Мэдлэгтэй туршлагатай чадварлаг эмч олон бий.

Жор мэдэхгүй эмчээс зовлон үзсэн чавганц дээр гэгчээр хүнээ зөв оношилж чадахгүй цагаан халаадтанд хэн цаазлуулахыг хүсэх билээ. Ард иргэдийн эрүүл мэндийн төлөө тангараг өргөж, мэргэжилдээ эзэн болсон чадварлаг, хүний төлөө гэсэн зүтгэлтэй эмч нарын алдар нэрийг ахиж бүү гутаагаасай.

Тиймээс улсын эмнэлгүүд хоорондын уялдаа холбоог сайжруулж, боловсон хүчнээр бүрэн хангагдаж ажиллах нь зүйд нийцнэ. Монгол хүний эрүүл мэнд юунаас ч илүү үнэтэй билээ.

Сурвалжилга

“Сэлбэ” голыг сэргээх үү, ширгээх үү?

Бидний нийслэл Улаанбаатар өнгөрсөн жилийн үерээс хойш “Усанбаатар” гэх нэрээ албан ёсоор авсан гэхэд хилсдэхгүй.

Бороо хур их, сүүлийн арван жилийн дунджаас илүү орсны улмаас зүүн, баруун Сэлбэ голууд үерлэж гамшгийн хэмжээнд хүрсэн. Хур борооны улирал аль хэдийн ирсэн, ахиад өмнө жилийн дунджаас дээш хур тунадас орвол “Усанбаатар” болохгүй гэх баталгаа байхгүй. Үерийн улмаас иргэд, албан байгууллагууд их хэмжээний хохирол амссаныг бид мэдэж байгаа.

Үүнээс хамгаалахын тулд нийслэлээс Сэлбэ, Дунд голын доторх бургасыг есөн тэрбум төгрөгөөр зөөн шилжүүлэх болжээ.

Үүнийг шинжлэх ухааны үндэслэлтэй, мэргэжлийн байгууллагын судалгааны хүрээнд хийх бөгөөд бургас болон бусад ургамал, бут сөөгийг “Туул” гол дагуу шилжүүлэх ажээ.

Энэ талаар хотын ерөнхий менежер Ц.Төрхүү: “Бид энэ бургасыг шинжлэх ухааны үндэслэлтэй зөөнө. Байгаль орчны яамны дүгнэлт гарсан байгаа. Энэ дүгнэлтийн дагуу зөөнө. Иймээс Сэлбэ голын далан, шугам сүлжээнд байгаа бут сөөгийг гурван байршилд зөөнө. Ингэж үерийн хамгаалалтын далан доторх бургас, бусад мод бутыг зөөснөөр үерийн даланг 1-1.5 метр гүн болгож, ус урсан өнгөрөх багтаамж хоёр дахин нэмэгдэх юм. Хэрэв энэ ажлыг хийхгүй бол нарны зам дагуух томоохон хотхон хороолол, барилга орон сууц үерт өртөх өндөр эрсдэлтэй гэсэн судалгаа гарсан” гэлээ. /Улаанбаатар, 2024 оны дөрөвдүгээр сарын 16 /МОНЦАМЭ/ агентлаг.

Өнгөрсөн жил нурах дөхсөн далангаа дахин засаж гүн болгохын тулд голын урсацыг дэмждэг бургасыг зөөнө гэлээ. Нэг талдаа энэ нь үерээс хамгаалж, нийтийн эрх ашгийг хангасан ажил боловч нөгөөтээгүүр Улаанбаатар хотын ундны усны хомсдол гэх мэт олон асуудлыг бий болгох сөрөг үр дагавартай.

Үерээс хамгаалж Сэлбэ гол дээр 16 газар голыг сүвлэж, шугам татжээ. Сэлбийг үерлэхээс хамгаалж голын урсацыг саармагжуулах олон ажил хийж байна. Гэтэл манай мэргэжилтнүүд нэг зүйлийг тооцоолоогүй бололтой. Тэр бол Сэлбэ голын ширгэлт. Сэлбэ гол тасарч ширгэвэл юу болох вэ?

Сэлбэ гол нь Хэнтийн нурууны урд хэсгийн салбар уулсад багтах бөгөөд далайн түвшнээс дээш 1510-1620 метр өндөрт оршдог. Нийт 342.2 километр квадрат нутгийг хамардаг. Энэ голын сав газарт ургамлын аймгийн долоон зүйл мод сөөг, 40 овгийн 183 зүйл ургамалтай. Амьтны аймгийн төрөл зүйл болох зараа, туулай, хэрэм, үнэг хярс, саарал чоно цөөн тоотой амьдарч, зэрлэг гахай, бор гөрөөс, хандгай, халиун буга, шилүүс гүйдлээр үзэгдэн, түр хугацаагаар байршин амьдардаг ажээ. Тэднийг цаашид нутагших бүрэн боломжтой гэж мэргэжилтнүүд үздэг.

Улаанбаатар хотын 1,6 сая иргэдийн экологийн тэнцвэрт эрүүл орчны чухал бүрдэл хэсэг юм.

Голын бохирдол, хог хаягдал усны стандартаас 10 дахин их байна. Гол бохирдож эхэлбэл хөрс, агаар болон байгаль орчны бусад бохирдол үүснэ. Санзайн амны эхэнд өдөрт дунджаар 1000 орчим машин тэрэг 4000-5000 хүн цуглан бужигнаж,

голын эхийг өтгөн шингэн ялгадсаар дүүргэж, ой мод, бутыг нь сүйтгэж, энд тэндгүй задгай гал түлж, хуурайшилттай өдрүүдэд түймрийн эрсдлийг нэмэгдүүлдэг.

Монголчууд бид гол усаа бохирдуулахаас цээрлэн сэргийлдэг ёс заншилтай ард түмэн. Гэтэл цөөн үлдсэн голынхоо эхийг нийслэлийн сая гаруй хүн очиж тээрэмдвээс “Сэлбэ” голын усны багахан нөөц тэсэх үү?

“Сэлбэ” голыг тэжээдэг байсан Хандгайт, Шарга морьт, Баянбулагийн амны жижиг голууд, Зүүн модны болоод Дондогдуламын рашаан бүгд ширгэн үгүй болжээ. Үерээс хамгаалах нэрийдлээр бут бургасыг зөөж усны түвшинг бууруулах ажлыг хийж байна. Гэвч энэ бүсэд байгалийн болоод экологийн тэнцвэрийг хангадаг олон амьтад амьдардаг. Энэ дэлхий дээр зөвхөн хүн хэмээн нэрлэгдэх байгаль орчноо хайрлан хамгаалахыг умартсан бид л амьдардаг юм биш шүү дээ. Голын урсац болон ай сав газрыг хөндөлгүй онгон дагшин төрхөөр нь дэлхийн стандартын дагуу үерээс хамгаалах шийдэл хэрэгтэй.

Гэтэл анх Сү. Батболдын санаачилгаар “Сэлбэ гол” төсөл нийтдээ долоон тэрбум гаруй төгрөгийн санхүүжилт батлуулан эхэлж, 2011 онд төсөл хэрэгжээд дуусах үед гол 22 метр өргөнтэй болно хэмээсэн боловч иргэд зүгээр л молиго үмхэж хоцорсон. Их тойруугийн гүүрнээс Арслантай гүүр хүртэлх 1.3 километр үерийн далангийн дагуу явган хүний зам, зүлэгжүүлэлт, гэрэлтүүлэг зэргийг барьж тохижуулна, хотын төв хэсэгт амралт зугаалгын бүс бий болгоно энэ ажилд есөн тэрбум төгрөг шаардлагатай гэж батлуулсан.

Мордохын хазгай гэгчээр “Норбуг” гэх компанийн зураг төсөл анхнаасаа буруу байсан. Төсөвлөсөн хэмжээнээс хөрөнгө нь дутсан гэх шалтгаанаар нүглийн нүдийг гурилаар хуураад орхисон байдаг.

Дараа нь Э.Бат-Үүл дарга бас л багагүй мөнгө авч, голыг мэлтэлзүүлэх гэсэн боловч талаар өнгөрсөн. Байгаль Орчин Аялал Жуулчлалын Яам 2012 онд “Сэлбэ” голын урсацыг тэтгэхээр тэрбум төгрөг хандивласан ч туршилт бас л талаар болсон гээд олон жишээ татаж болно. Энэ байдлаараа бол бороо хуртай үед хог шороотой холилдож булингартан урсдаг “Сэлбэ” гол амь тавьж, үерийн далан нь хогийн тантан болох цаг удахгүй ирэх бололтой. “Сэлбэ” гол нөхөн сэргээгдэж зуны улиралд амралт зугаалгын төв, өвөлдөө мөсөн гулгуурын талбай болно гэдэг нь мөрөөдөл болон үлдсэн.

Өнгөрсөн жил “Сэлбэ гол төсөл” удирдагчаар олноо “дух” хэмээн танигдсан жүжигчин Б.Цэцэг төслийг удирдах болсон нь нэлээд шуугиан, хэл ам гаргаад амжсан. Өнөөгийн байдлаар нүд нь балай чих нь дүлий хэвээр л байна.

Ирэх арван жилд ундны усны хэрэглээ хоёр дахин өснө гэж холбогдох албаныхан сануулж байгаа. Ундны усны хомсдолд орохгүйн тулд усны эх үүсвэрээ хадгалан авч үлдэх нэн шаардлагатай байна. Улаанбаатарын ундны усны нэлээд хувийг эзэлдэг “Туул” голд баруун “Сэлбэ” цутгадаг. Харамсалтай нь “Сэлбэ” голын эхийг сүвэгчлэн боож мөн зүүн “Сэлбэ”, “Ногоон нуур”, “Баян бүрд”-ийн урсац нь тэр хавийн айл өрхийн хог хаягдалд бохирдон мөн суваг татуулж боолгосноор ширгэсэн. Үүнээс үүдэн “Туул” гол ч багасан ундны усны асуудал улам л газар авсаар.

Өнгөрсөн есдүгээр сараас эхлэн Улаанбаатар хотын хөрсний усыг шавхан зайлуулж /ус шууруулж/ байгаа.

Яг одоогийн байдлаар долоон газарт ус шууруулж байгаа гэсэн компаниудын дүгнэлт гарсан.

Долоон газрын дүгнэлтийг авч үзэхэд зөвхөн барилгын шүүрлийн ажлаар 2.4 сая

шоо метр усыг зайлуулж байна. Улаанбаатар хотод УСУГ-аас хоногт 150,000 шоо метр усыг нийлүүлдэг. Гэтэл 2.4 сая шоо метр ус буюу нийслэлийн наймаас ес хоногийн хэрэгцээний усыг гол руу болон бохир усны шугам руу хаяж байна. Цэнхэр алт болсон ус улам л хомсдсоор.

Орос улсаас хүртэл мэргэжилтэн авчирч ажлуулсан. Сэлбэ төсөл аль шатандаа, ямар ахиц дэвшил гарсан явж буй талаар нийтэд өгсөн мэдээлэл байхгүй. Сэлбэ , Дунд гол дээр очиж үзвэл бохирдон, ширгэх дөхсөн нарийхан голдрилоор усны шувууд биш, ус ундааны сав хог хаягдалтай хамт урсаж байна.

Сэлбэ голыг аварч мөн үерээс хамгаалж нэг сумаар хоёр туулай буудах шийдэл арга нь стандартад нийцсэн далан барих. Гэвч ойролцоогоор нэг километр даланг тэрбум төгрөгөөр барьдаг аж. Тиймээс үерийн далан барих төсвийг нийслэл дангаараа даахгүй улсын төсөв дээр тавих ёстой. Төр иргэдээ эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөл боломжоор хангах үүрэгтэй. Гэтэл тэд чадсангүй. Чаддагаараа олон улсын байгууллагууд руу хандаж байгаа хэмээн мэргэжлийн хүн хэллээ. Аялал зуучлалын томоохон бүс болж моторт завиар зуны орой Сэлбийн хөвөөгөөр сэрүүцэн давхих нэгэнт мөрөөдөл болжээ.

Сэлбийн эх 2000 гаруй га энэ газрыг 2012 онд нийслэлийн иргэдийн хурлын шийдвэрээр орон нутгийн тусгай хамгаалалтанд авсан байдаг. Гэтэл хууль зөрчин байгаль сүйтгэх ажил хийсээр, урд хормойгоороо хойд хормойгоо нөхсөөр л сууна даа.

Үүнээс салж асуудлыг шийдэх бас нэг шийдэл гарч байгаа нь эхний ээлжинд Хандгайт, Баруун Сэлбийн уулзвар дээр ус хуримтлуулах хиймэл цөөрөм усан сан нэн даруй байгуулах шаардлагатай байна. Хандгайт, Сэлбэ, бусад жижиг голуудыг боож, усан сан барих нь шар усны үер болон борооны ус хуримтлуулж, Сэлбэ голын урсгалыг тогтмол хэмжээнд байлгах, үерээр орж ирэх элс, шороог тунгааж авах ажлыг хийх шаардлагатай.

“Шимдэс шиг гол нэг л үүрээр

Шивнээ нь тасарч, амьсгалаа өвөр дээр чинь хураах нээ!”

Хэмээн яруу найрагч Ц.Чимиддорж "Сэлбэ" гэх шүлгэндээ дурдсан байдаг.

Шийдвэр гаргах гэж оролдож буй дарга нарын хэлсэн үг биелэлээ олтол “Сэлбэ” гол сэргэх үү, ширгэх үү?

**Монгол Улсын Боловсролын Их Сургууль
Сэтгүүл зүйн тэнхимийн 3-р дамжааны оюутан
Б.Нарантуул**